

## МОНГОЛ УЛСЫН ТЭТГЭВРИЙН НЭРИЙН ДАНСНЫ ЗАРИМ АСУУДАЛД

Б.Батжаргал\*

**Хураангуй:** Улс бүр өөрийн онцлогт тохирсон тэтгэврийн тогтолцоог бий болгож, хэрэгжүүлж, хөгжүүлдэг ба энэхүү тогтолцоо нь зохистой байх, санхүүжүүлэх чадвартай, тогтвортой байдал, шударга, тэгш хүртээмжтэй байх, урьдчилан мэдэх боломжтой, тэсвэртэй байдал зэрэг шалгуурыг<sup>2</sup> хангаж байдаг. Монгол Улсад 2015 оноос эхлэн 55 насанд хүрсэн эмэгтэй даатгуулагчдад өндөр насны тэтгэврийг шимтгэлд суурилсан бодолтоор тогтооход цалинд суурилсан аргаар тооцсоноос 30 % догуур тогтоогдож эхэлсэн. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансыг нэвтрүүлсэн он, тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэврийн бодолт, түүний санхүүжилтийг тодорхой хугацаанд өөр сангаас олгох, шимтгэлийн хэмжээг тус тус өөрчилсөн. Үүнтэй холбоотойгоор өндөр насны тэтгэврийн бодолт, баталгаат доод хэмжээний тэтгэврийг олон давхаргат тэтгэврийн тогтолцоотой уялдуулах замаар шийдвэрлэх шаардлагатай байна.

**Түлхүүр үг:** өндөр насны тэтгэвэр, хийсвэр нэрийн данс, шимтгэлд суурилсан тэтгэвэр

**Судалгааны зорилго:** Энэхүү судалгаа нь Монгол Улсад тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нэвтрүүлэхэд тулгамдсан буй асуудлуудыг илрүүлж, даатгуулагчийн ирээдүйн нийгмийн баталгааг хангах санал гаргалаа.

**Судалгааны арга зүй:** Энэхүү судалгаанд харьцуулан жиших, нэгтгэн дүгнэх, математик статистикийн арга болон прост программыг хэрэглэв.

---

\*МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) batja\_ses@yahoo.com

<sup>2</sup>Дэлхийн банк “Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн ойлголтууд цуврал-Тэтгэврийн тогтолцооны тухай үндсэн үзэл баримтлалууд” УБ, 2012

**Судлагдсан байдал:** Даатгуулагчийн тэтгэвэрт гарах шийдвэрт тухайн даатгуулагчийн өөрийн болон гэр бүлийн гишүүдийн ажил эрхлэлт, орлого, эрүүл мэнд, гэр бүлийн гишүүдийн тоо, тэдгээрийн бие даасан байдлаас ихээхэн хамааралтай. Даатгуулагчийн авах тэтгэврийн хэмжээг ажлаа үргэлжлүүлэн хийснээр олох орлоготой харьцуулсан харьцаа нь өндөр байх тусам тэтгэвэрт гарах сонирхол өндөр байдаг. Үүнийг тэтгэвэр тогтоох хувь хэмжээ буюу орлуулалтын хувь (Replacement rate) гэж нэрлэдэг. Орлуулалтын хувийг оновчтой тогтоох нь тэтгэврийн тогтолцооны үндсэн шалгуур үзүүлэлтийг хангахад чухал үзүүлэлт болдог байна. Энэ хувь нь даатгуулагчийн авч байсан цалинтай шууд уялдаатай. Жишээ нь, даатгуулагчийн тэтгэвэр бодох орлуулалтын хувь хэдий өндөр боловч авч байсан цалин бага бол өндөр тэтгэвэр тогтоогдох магадлал бага юм.

Даатгуулагч ажиллаж, шимтгэл төлж, улмаар тэтгэвэр тогтоолгох болзол, нөхцөлийг хангасан тохиолдолд тэтгэврийг дараах хоёр аргын аль нэгээр тогтоож байна. Үүнд:

Даатгуулагчийн шимтгэл төлсөн ямар нэг хугацааны цалингийн дунджийг тооцож, тэр дүнгээс тодорхой хувиар бодохыг хэлнэ. Дэлхийн улс орнуудын 70 орчим хувь нь энэ аргаар тэтгэвэр тогтоож байгаагийн дотор манай улс орж байна. Хөгжиж буй орнуудын гуравны хоёр нь, Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын 40 хувь нь даатгуулагчийн ажил хөдөлмөр эрхэлж, сүүлийн жилүүдэд авч байсан цалинг тэтгэвэр тогтооход ашиглаж байна. Мөн нийт улс орны тавны нэг нь даатгуулагчийн хамгийн өндөр орлого олж байсан 1 жилийн орлогыг ашиглаж байгаа бол, хөгжиж буй орнуудын гуравны нэг нь, Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын 15 хувь нь даатгуулагчийн насан туршийн орлогын дунджаас тооцон тэтгэвэр бодож байна.<sup>3</sup> Богино хугацааны цалин ашиглаж тэтгэврийг тооцож буй орнууд даатгуулагчийн насан туршид авч байсан цалингийн дунджийг ашиглан тэтгэвэр тогтоох чиглэл баримталж байна.

3 Б.Батжаргал (2016), “Нийгмийн даатгал”

Олон жил ажиллаж шимтгэл төлж ажиллах нь даатгуулагчид ашигтай хэдий ч цөөн жилийн цалингаар харьцангуй өндөр тэтгэвэр тогтоолгон, урт хугацаанд тэтгэвэр авах боломжтой байдаг тул үүнд эрх баригчид зарим зохицуулалт хийдэг. Жишээ нь, тогтоосон тэтгэврийн наснаас эрт тэтгэвэрт гарах бол тэтгэвэр бодох хувийг бууруулах, тэтгэврийн насанд хүрсэн боловч ажиллаж байгаад тэтгэвэрт гарах бол бодох хувийг нэмэгдүүлэх, шимтгэл төлөх жилийн доод, дээд хугацаанд хязгаарлалт хийх зэрэг болно.

Цалинд суурилсан тэтгэврийн бодолтыг ихэвчлэн 1 дүгээр давхарга буюу улсын тэтгэврийн тогтолцоонд ашигладаг ба санхүүжилт нь хуваарилалт (PAYG)-ын зарчимд үндэслэж байна.

Шимтгэлд суурилж тэтгэвэр бодох арга: (Defined contribution) (ШС) гэдэг нь даатгуулагчийн авах тэтгэврийн хэмжээ нь түүний төлсөн нийт шимтгэл, шимтгэлийг хөрөнгө оруулалтад оруулсны өгөөж, тэтгэвэрт гарснаас хойш амьдрах хугацаанд үндэслэн тогтоодог аргыг хэлнэ. Энэ аргын нэг загвар нь 1988 оноос эхлэн эрчимтэй судлагдаж, 1990 оны дунд үеэс зарим оронд, 2000 оноос нилээд олон оронд хийсвэр нэрийн дансны арга (Notional defined contribution) нэртэйгээр нэвтэрсэн. Энэ арга нь даатгуулагчийн тэтгэврийн даатгалд төлсөн шимтгэлийг дансанд зөвхөн хийсвэрээр жил бүр хүү тооцон бүртгэж, шимтгэлд тооцсон хүү нь зах зээлийн хөрөнгө оруулалтын бодит өгөөж биш Засгийн газраас тогтоосон бодит бус хүү байдаг. Энэ хүүг тогтоохдоо инфляцийн түвшин, хэрэглээний үнийн өсөлтийг харгалзан үзсэн байдаг.

Хийсвэр нэрийн данс гэж нэрлэж буй шалтгаан нь шимтгэлийн орлогоор бүрдсэн тэтгэврийн сангийн мөнгөн хөрөнгө бодитоор байхгүй бөгөөд даатгуулагчийн ирээдүйд авах тэтгэврийн авлагын бүртгэл тооцоо л байна гэсэн үг юм. Харин тогтоосон тэтгэврийг олгох санхүүжилт нь хуваарилалтын зарчмаар явагддаг нь цалинд суурилсан уламжлалт аргатай адил.

Даатгуулагч тэтгэврийн насанд хүрэхэд түүний нэрийн дансанд хийсвэрээр хуримтлагдан бичигдсэн нийт үлдэгдлийг тэтгэвэрт гарснаас хойшхи амьдрах хугацаанд хуваах замаар нэг сард ногдох тэтгэврийг тооцоолон гаргадаг.

Эрэгтэй, эмэгтэй даатгуулагчийн тодорхой наснаас хойш амьдрах хугацааны тооцооллыг улсын насжилтын хүснэгтэд үндэслэн тооцох бөгөөд энэ нь жил бүр өөр өөр байна. Сүүлийн үед Итали (1995), Латви (1995-

1996), Польш, Швед (1998)<sup>4</sup> зэрэг улсад хийсэн тэтгэврийн шинэчлэл нь хийсвэр нэрийн дансны тогтолцоог нэвтрүүлэхэд чиглэсэн.

Хуваарилалтын зарчмаар явагдаж байсан санхүүжилтийг бүрэн хуримтлалын тогтолцоогоор солиход тулгардаг нэг гол бэрхшээл нь шилжилтийн зардал бөгөөд үүнийг улсын төсөв татвараас, эсвэл тэтгэврийн даатгалын сангаас ч санхүүжүүлэхэд төвөгтэй тул санхүүжилтийг хуваарилалт (PAYG)-ын зарчмаар хийдэг.

Хийсвэр нэрийн дансны шинэчлэлийн гол агуулга нь даатгуулагчийн тэтгэврийн хэмжээг түүний төлсөн нийт шимтгэлийн хэмжээтэй уялдаатай болгоход оршино. Швед улсын тэтгэврийн шинэчлэлийг хийсэн Эдвард Палмер “Хийсвэр нэрийн дансны гол шинж чанар нь шударга тогтолцоо юм”<sup>5</sup> гэж үзсэн. Хийсвэр нэрийн дансны аргыг цалинд суурилсан тэтгэврийн аргатай жишвэл даатгуулагчийн насан туршийн орлогод үндэслэн тэтгэвэр бодох аргатай төстэй гэж үзэж болно.

Хуваарилалтын санхүүжилттэй шударга нийгмийн даатгалын систем гэдэг нь даатгуулагчийн хойч үе болгоны төлсөн шимтгэлд цалингийн бүтээмж болон хөдөлмөр эрхлэлтийн бүтээмжтэй тэнцүү хэмжээний өгөөж олгох юм. Энэ шударга өгөөж нь эдийн засгийн өсөлтөөс тэтгэврийн систем зарцуулах боломжтой хэсгийг илэрхийлнэ гэж Паул Самуэлсон 1958 онд<sup>6</sup> тодорхойлсон.

Даатгуулагч нэрийн дансны тогтолцооны үед төлсөн шимтгэлийг татвар гэж бус ирээдүйн өөрийн хуримтлал гэж үздэг хандлага байдагт бас нэг давуу тал оршиж байгаа юм.

Монгол улсын хувь 1958 онд баталсан “Тэтгэврийн тухай хууль”, 1990 онд баталсан “Тэтгэврийн тухай хууль”, 1994 онд Улсын Их Хурлаас “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д тэтгэврийг цалинд суурилсан аргаар тогтоохоор заасан. Харин 1999 онд “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуулийг баталж, 1960 оноос хойш төрсөн бүх иргэд шимтгэлд суурилсан аргаар тэтгэвэр тогтоолгохоор заасан. Мөн 1999 онд Улсын Их Хурлаас “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл”-ийг баталж, үүнд нэрийн дансны тодорхой хэсгийг мөнгөжүүлж, хөрөнгө оруулалт хийж, өсгөх тухай

4 Дэлхийн банк (2012) “Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн ойлголтууд” цуврал

5 “ Дэлхийн банк (2012) “Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн ойлголтууд” цуврал

6 “ Дэлхийн банк (2012) “Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн ойлголтууд” цуврал

тусгасан боловч өнгөрсөн хугацаанд хэрэгжээгүй.

Дэлхийн банк (ахлах зөвлөх Марк Дорфман)-ны 2012 онд хийсэн "Тэтгэврийн бодлогын шинэчлэлийн хувилбарууд" тайланд 1959 ба 1960 онд төрсөн 2 эмэгтэй даатгуулагчийн хувьд тэтгэвэр тогтоох хувь хэмжээ 2014 онд 40-50 хувь, 2015 онд 32-35 хувь<sup>7</sup> болж ялгаатай байх талаар урьдчилан гаргаж байсан бол, Н.Тунгалаг нарын нэг сэдэвт өгүүлэл<sup>8</sup> нэрийн дансны үлдэгдлээр амьжиргааны баталгаажих доод түвшинг хангах хэмжээний тэтгэврийг тогтоох боломжгүй тухай судалж, асуудал дэвшүүлжээ.

### Үндсэн хэсэг

"Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай" хуульд 1960 ба түүнээс хойш төрсөн бүх даатгуулагч нэрийн данстай байх бөгөөд 180 ба түүнээс дээш сар шимтгэл төлсөн эмэгтэй 55, эрэгтэй 60 насандаа өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй гэж заасны дагуу 2015 онд энэхүү болзлыг хангасан 15.0 мянган эмэгтэй даатгуулагч өндөр насны тэтгэврийг шимтгэлд суурилсан аргаар тогтоолгох болов. Нэг сард олгох тэтгэврийг дараах томъёогоор бодсон болно. Үүнд:

$$T = \frac{X}{K} : 12$$

X- нэрийн дансны нийт орлого

K- тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (2015 оны байдлаар 22.5<sup>9</sup> жил)

Дээрх 15.0 мянган даатгуулагчийн 7.2 мянга нь нийслэлийн 9 дүүрэгт, 7.8 мянга нь 21 аймагт амьдарч байсан бөгөөд нэрийн дансны томъёогоор бодсон бодит тэтгэврийн хэмжээг хүснэгт 1-ээр харуулав.

7 " Дэлхийн банк (2012 ) "Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн ойлголтууд" цуврал

8 Монгол Улсын тэтгэврийн даатгалын сангийн бүрдэлт хуваарилалтын тулгамдсан асуудал Н.Тунгалаг , Л.Оюунцэцэг нар 2013 он

9 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2014 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 30 дугаар тогтоол

Хүснэгт 1. Монгол Улсын зарим эмэгтэй даатгуулагчдын  
тэтгэврийн хэмжээ /2015 он/

№	Нэрийн дансны аргаар тогтоогдох бодит тэтгэврийн хэмжээ /төгрөг/	Тэтгэвэр авагчдын тоо	Эзлэх хувь	Тэтгэврийн доод хэмжээ	
				Нэрийн дансны тухай хуулиар <sup>1</sup> /хөдөлмөрийн хөлсний улсын дундаж хэмжээ 2015 онд 808 мянга төгрөг <sup>2</sup> /	Цалинд жишсэн аргаар тэтгэвэр авагчдын хувьд /Засгийн газрын 2015 оны 52 дугаар тогтоол, төгрөг/
1	50000-172200	11988	79.7	161 600	Хувь тэнцүүлсэн тэтгэвэр-195 000  Бүрэн тэтгэвэр -230 000
2	172201-207300	629	4.2		
3	207301-300000	1299	8.6		
4	300001-500000	957	6.4		
5	500001- с дээш	168	1.1		
	Нийт	15041	100		

Дээрх судалгаанаас үзэхэд 2015 онд өндөр насны тэтгэврийг нэрийн дансны аргаар тогтоолгосон даатгуулагчийн бараг 80 хувь нь нэрийн дансны тухай хуулиар тогтоосон доод хэмжээ буюу 161600 төгрөгөөр тэтгэвэр тогтоолгохоор гарсан бөгөөд энэ нь цалинд суурилсан аргаар тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн доод хэмжээнээс 20.1 %-иар бага байсан гэсэн үг юм.

Дээрх хоёр аргачлалыг тухайн нэг даатгуулагч дээр жишээ болгон авч үзвэл: Даатгуулагч нь 1960 оны 12 сарын 15-нд төрсөн, 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар нэрийн дансны эцсийн үлдэгдэл нь 35 709 998.52 төгрөг байна. 2015 оны 12 дугаар сарын 15-нд тэтгэвэр тогтоолгох эрх нь үүсэн 2 аргаар бодолт хийхэд:

-Шимтгэлд суурилсан аргаар тэтгэвэр тогтооход 132 259.2 төгрөг байхад,

-Цалинд суурилсан аргаар тэтгэвэр тогтооход 204 920.7 төгрөг буюу 54.9 хувийн зөрүүтэй тэтгэвэр тогтоолгохоор байна. Дээрх 15.0 мянган даатгуулагчийн тэтгэврийг цалинд суурилсан аргаар бодоход ямар үр дүн гарч байгааг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. Монгол Улсын эмэгтэй даатгуулагчдын тэтгэврийг цалинд суурилсан аргаар тооцсон хэмжээ /2015 он/

№	Үзүүлэлт	Тэтгэвэр тогтоологх иргэдийн тоо	Эзлэх хувь
1	Зөрүү нь 0 буюу ижил хэмжээтэй тэтгэвэр тогтоологх иргэд	431	2.9
2	Нэрийн дансны хуулиар бодсон дүнгээс цалинд суурилсан аргаар тэтгэврээ өндөр тогтоологх боломжтой иргэд	11297	75.1
3	Цалинд суурилсан аргаар бодоход нэрийн дансны хуулиар бодсоноос бага төгрөгийн тэтгэвэр тогтоологх иргэд	3313	22.0
	<b>Нийт</b>	<b>15041</b>	<b>100</b>

Судалгаанаас харахад цалинд суурилсан аргаар бодоход нийт даатгуулагчийн 75.1 хувь нь шимтгэлд суурилсан аргаар бодсоноос өндөр тэтгэвэр авах бол ижил хэмжээний тэтгэвэр тогтоологх боломжтой иргэд 431 байна.

Харин 3313 даатгуулагчийн хувьд сөрөг буюу шимтгэлд суурилсан аргаар тэтгэвэр бодох нь ашигтай байгаа судалгаа гарчээ.

Тэтгэврийн өсөлтийн зөрүүг судалбал сонирхолтой үзүүлэлт гарна. Үүнийгдараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 3. Тэтгэвэр нь өндөр гарах 3313 даатгуулагчдын тэтгэврийн өсөлтийн судалгаа

№	Үзүүлэлт /төгрөг/	Тэтгэвэр тогтоологх иргэдийн тоо	Эзлэх хувь
1	10000 хүртэл	340	10.3
2	10001-50000 хүртэл	1103	33.3
3	50001-100000 хүртэл	824	24.9
4	100001-200000 хүртэл	723	21.7
5	200001-300000 хүртэл	243	7.3
6	300001-500000 хүртэл	74	2.3
7	500001- с дээш төгрөгийн өсөлттэй	6	0.2
	<b>Нийт</b>	<b>3313</b>	<b>100.0</b>

Дээрх тооцоолоос үзэхэд 50 мянга хүртэл төгрөгийн өсөлттэй иргэдийн тоо 43.3 хувь буюу 1443 даатгуулагч байна. Энэ нь хэрвээ нэрийн дансны

эцсийн үлдэгдлийн тооцооллыг алдаатай болон буруу хийсэн шалтгаанаар өөрчлөлт орвол энэ хэмжээний даатгуулагч шимтгэлд суурилсан биш цалинд суурилсан аргаар тэтгэвэр тогтоолгох болно гэсэн үг юм.

Тооцооллыг улам бататгах үүднээс 2015 оны 01 дүгээр сараас 7 дугаар сар хүртэлх хугацаанд цалинд суурилсан аргаар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон<sup>10</sup> 5 768 эмэгтэй даатгуулагчийг судлахад дараах байдалтай байна.

Хүснэгт 4. Цалинд суурилсан аргаар тэтгэвэр тогтоолгосон иргэдийн судалгаа

№	Үзүүлэлт	Тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тоо	Эзлэх хувь
1	Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээгээр тогтоолгосон иргэд /195,000/	773	13.4
2	195,001-229,999 хүртэлх төгрөгийн тэтгэвэр тогтоолгосон иргэд	17	0.3
3	Бүрэн тэтгэврийн доод хэмжээгээр тогтоолгосон иргэд /230,000/	3494	60.6
4	230,001-350,000 хүртэл төгрөгийн тэтгэвэр тогтоолгосон иргэд	685	11.9
5	350,001с дээш	799	13.9
	Нийт	5768	100

Судлаачийн зүгээс тэтгэвэр бага тогтоогдох болсон шалтгааныг илрүүлж, нотлохоор дараах асуултыг тавьж, хариулт өгөхийг зорилоо. Үүнд:

1. Нэрийн данс нээх оныг зөв сонгосон уу? /Нэрийн дансны гарааны үлдэгдлийг бодсон аргачлал зөв байсан эсэх/;
2. Нэрийн дансны хүүг багаар тогтоосон уу? /хангалттай хэмжээгээр өсгөөгүй юу/;
3. Өндөр насны тэтгэвэр бодох аргачлал болон амьдрах хугацааны илэрхийлэл алдаатай байсан эсэх?
4. 1960 оноос хойш төрсөн даатгуулагч тахир дутуу болсон, нас барсан бол тэжээгчээ алдсаны тэтгэвэр нэрийн дансны хуулиар олгосон эсэх?

<sup>10</sup> Улсын Их Хурлаас 2015 оны 5 сард баталсан “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар даатгуулагч аль өндөр тогтоогдох хувилбарыг сонгох эрхтэй болсон.




### Нэрийн дансны гарааны үлдэгдлийг бодсон аргачлалыг бодитой тогтоосон уу?

Хуулийн дагуу 1960 ба түүнээс хойш төрсөн бүх иргэдэд 2000 онд хийсвэр нэрийн данс нээсэн ба 2015 оны эхний хагас жилийн байдлаар 1.3 сая даатгуулагчийн нэрийн дансанд нийт 13.3 их наяд төгрөгийн шимтгэл болон түүнд тооцсон хүүг хийсвэрээр бүртгэсэн нь нэг хүнд дунджаар 9.9 сая төгрөг ногдож байна.

Хийсвэр нэрийн данс нээлгэсэн 1960, 1965, 1970, 1975, 1980 төрсөн даатгуулагчийн тоог 2000-2015 оныг хамруулан судлахад<sup>11</sup> дараах байдалтай байна.

Зураг 1. Хийсвэр нэрийн данс нээлгэсэн даатгуулагчдын тоо /2000-2015 он/



Дээрх графикаас харахад 1960 онд төрсөн 10752 хүн 2000 онд хийсвэр нэрийн данс нээлгэж байсан бол 2010 онд 12 392, 2015 онд 12 999 байжээ. Энэ дүн нь сонгогдсон бүх онуудын үзүүлэлтээс бага байгаа бөгөөд хэдий тэтгэвэр тогтоолгосон байх магадлалтай боловч энэхүү бага байгааг дараах шалтгаанаар тайлбарлаж болно. Үүнд:

- Тэд 20 насандаа ажиллаж эхэлсэн гэж тооцвол шимтгэл төлдөггүй үед буюу 1980-1995 он хүртэл хугацаанд аль хэдийн 15 хүртэл жил ажилласан байсан тул нэмж шимтгэл төлөх шаардлагагүй гэж үзсэн;

<sup>11</sup> Тэтгэвэр тогтоолгосон иргэдийг хасаж тооцоолов.

- 1991 оноос эхэлсэн нийгмийн өөрчлөлтийн хүрээнд тэдгээрийн ихэнхи нь ажилгүй болсноор хэдий сайн дурын даатгалд хамрагдах боломжтой байсан ч хамрагдаагүй;
- 2000 онд тэд 40 настай байсан бөгөөд нэрийн дансны тухай хуулиар гарах тухай ойлголтгүй байснаас цалинд суурилсан аргаар тэтгэвэрт гарахад бэлдэж сүүлийн 5 жилийг ямар нэг байдлаар өндөр төлөхөд бэлдэж байсан зэрэг болно.

Шимтгэлд суурилсан аргаар тэтгэвэр тогтоолгох аргад шимтгэл төлдөггүй байх үеийн ажилласан жилтэй хүмүүсийг хамруулсан нь буруу байсан нь үүгээр нотлогдож байна. Ийм дүр зураг 1960 оноос 1980 он хүртэл төрсөн хүмүүст ажиглагдаж байгаа бөгөөд 1980 оноос өөр байдал гарч байна.

Мөн 1995 он хүртэл ажилласан хүний энэхүү жилийг хийсвэр нэрийн дансны эхний үлдэгдэлд шилжүүлэн дараах байдлаар тооцохыг “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуульд заасан. Эхний үлдэгдэл нь даатгуулагчийн 1999 оныг дуустал ажилласан хугацаа, 1995-1999 онд тэтгэврийн даатгалын санд төлсөн шимтгэлийн дүнд үндэслэн тооцогддог.

Эхний үлдэгдэл = Б х В

Б= сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээ,

В= ажилласан нийт сар

Харин “Б” гэсэн үзүүлэлтийг дараах байдлаар тооцохоор заасан. Үүнд:

Б=Г х Д х Е

Г= даатгуулагчийн сарын хөдөлмөрийн хөлсний дундаж хэмжээ,

Д= сүүлийн 5 жилийн улсын дундаж хөдөлмөрийн хөлсний дундаж индекс,

Е=шимтгэлийн хувь хэмжээ

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2010 оны тогтоолоор 2 дугаар тогтоолоор 1995-1999 оны цалинг өсгөх индексийг 10.06, 4.6, 3.83, 3.54, 3.22 гэж баталсан байна. Харин 1995 оноос өмнө авч байсан цалинг өсгөх индексийг батлаагүй ба Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2010 оны 108 дугаар тушаалаар баталсан “Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны харилцааг зохицуулах журам”<sup>12</sup>-д “1995 оноос өмнө ажиллаж байсан боловч 1995 оноос хойш нэрийн данс нээлгэх хүртэлх хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлж ажиллаагүй даатгуулагчийн

<sup>12</sup> “Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны харилцааг зохицуулах журам”-ын 3.5.2

сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг Засгийн газраас тогтоосон тухайн үед буюу 1995-1999 онд мөрдүүлж буй цалин хөлсний доод хэмжээгээр тооцно” гэж зааснаас хамааран зөвхөн ажилласан хугацаа нь л бодитоор тооцогдох нөхцөл байдал үүссэн байна.


Ингэснээр 1995 оноос өмнө ажилласан жилтэй (гэхдээ шимтгэл төлөөгүй) байсан 1960-1980 он хүртэл иргэдийн хийсвэр нэрийн дансны эхний үлдэгдлийг тооцохдоо авч байсан цалинтай уялдуулаагүй, цалинг өсгөх индекс тухайлан батлаагүй, шууд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцсон байна.

### Нэрийн дансны хүүг багаар тогтоосон уу /хангалттай хэмжээгээр өсгөөгүй юу/?

Даатгуулагчийн хамгийн ихээр сонирхдог зүйл бол хэдий энэ дансны үлдэгдэл хийсвэр боловч миний хуримтлуулсан үлдэгдлийг банкны хадгаламжийн хүүнээс өндөр хүүгээр өсгөн байна уу? гэсэн асуулт юм.

Хийсвэр нэрийн данс нээсэн 2000 оноос эхлэн 2016 он хүртэл үлдэгдэлд жилийн хэдэн хувиар хүү бодсоныг бусад үзүүлэлттэй<sup>13</sup> харьцуулан дараах зураг №2 –г харуулав.

Зураг 2. Хийсвэр нэрийн дансны хүүг зарим үзүүлэлттэй харьцуулсан нь



<sup>13</sup> Монголбанкны Mongolbank.mn цахим хуудас болон ҮСХ-ны 1212.mn цахим хуудааснаас


Судалгаанаас үзэхэд нэрийн дансны жилийн хүү 2000-2016 онуудад тухайн жилийн инфляциас өндөр байсан бөгөөд хамгийн их нь 2003 онд жилийн 32 % хүрч байжээ. Харин арилжааны банкны хугацаатай хадгаламжийн жилийн хүүтэй харьцуулахад 2009-2013 онуудад хамгийн өндөр байсан бол 2016 онд банкны хүү жилийн 18 байсан бол нэрийн дансны хүү 7.3 % болж багаар тогтоогджээ.

“Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуульд<sup>14</sup> нэрийн дансанд хүү тооцоход эхний үлдэгдэл, тухайн жилийн шимтгэлийн орлогын нийлбэрийг дундаж хөдөлмөрийн хөлсний сүүлийн 3 жилийн дундаж өсөлтийн хувиар үржүүлэхээр заасан. Энэ нь хүүний хэмжээ цалингийн өсөлттэй шууд уялдаатай болсон бөгөөд цалинг инфляцтай бус улс төрийн шийдвэрээр огцом нэмсэн жилүүд (2009-2012)-эд нэрийн дансны хүүний хэмжээ тухайн жилийн инфляци болон банкны хадгаламжийн хүүнээс хэт өндөр тогтоогдож иржээ.

Энэ судалгаанаас үзэхэд нэрийн дансны хүүг хэт багаар тогтоогоогүй бөгөөд харин ч зарим жилүүдэд инфляциас 7 дахин, хадгаламжийн хүүнээс 1.5 дахин өндөр хүүг тогтоож хийсвэр нэрийн дансны үлдэгдлийг жил бүр өсгөж байжээ.

Даатгуулагчийн хийсвэр нэрийн дансны нийт үлдэгдлийн хэдэн хувийг даатгуулагчаас төлсөн шимтгэл, хэдэн хувийг хүүгээр өссөн дүн эзэлж байгааг сонгосон онууд болон нэрийн данс нээлгэсэн бүх иргэдийн хувьд тооцож Зураг 3-т үзүүлэв.

Зураг 3. Монгол Улсын даатгуулагчдын хийсвэр нэрийн дансанд хуримтлуулсан бодит төлсөн шимтгэл ба хүүний өсөлтийн харьцуулсан үзүүлэлт



14 “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуулийн 6.2 дахь хэсэг

Судалгаанаас үзэхэд 1960 онд төрсөн иргэдийн хийсвэр нэрийн дансны нийт үлдэгдлийн зөвхөн 11.2 хувь нь бодитоор төлсөн шимтгэл, харин 88.8 % нь хүүний орлого байгаа нь бусад бүх оноос бага байна. Нийт дүнгээр энэ үзүүлэлт 21.6:78.4 гэсэн харьцаатай байгаа нь нэрийн дансны хүү өндөр байгааг нотолж байгаа юм. Мөн энэ үзүүлэлт тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ бага (2008 онд 19-өөс 14 хувь болгож бууруулсан) байгааг, даатгуулагч бага цалингаас шимтгэл төлж байгааг тус тус харуулж байна.

**Өндөр насны тэтгэвэр бодох аргачлал болон амьдрах хугацааны илэрхийлэл алдаатай байсан эсэх?**

Өндөр насны тэтгэврийн томъёог дээр илэрхийлсэн бөгөөд үүнд алдаа байхгүй байна. Харин “К” үзүүлэлт буюу амьдрах хугацааны илэрхийлэл 2015 онд 22.5 байгаа нь зөв эсэхийг нягтлах зорилгоор прост программаар хийсэн тооцооллыг Хүснэгт 5-д харуулав.

Хүснэгт 5. Даатгуулагчдын өндөр насны тэтгэвэр авах амьдрах хугацааны илэрхийллийн үзүүлэлт

	2013	2020	2030	2040	2050	2060	2070	2080	2085
Эрэгтэй хүн ам									
55 наснаас хойш	18.3	19.2	20.3	21.7	22.5	23.3	24.2	25.1	25.1
60 наснаас хойш	15.0	15.8	16.2	16.7	17.9	18.6	19.3	20.1	20.9
65 наснаас хойш	12.2	12.8	13.1	13.5	14.5	15.1	15.7	16.3	17.0
Эмэгтэй хүн ам									
55 наснаас хойш	22.8	23.5	24.6	26.3	27.1	27.9	28.7	29.7	29.7
60 наснаас хойш	19.1	19.7	20.2	20.7	22.2	22.8	23.6	24.3	25.2
65 наснаас хойш	15.7	16.2	16.6	17.0	18.3	18.8	19.4	20.1	20.8

Дээрх судалгаанаас үзэхэд 2013 оны байдлаар 55 насанд хүрсэн эмэгтэй дунджаар 22.8 жил амьдарч тэтгэвэр авахаар тооцоолол гарсан нь 22.5 жилтэй тохирч байгаа болно.

“Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай” хуулиар тахир дутуугийн тэтгэврийг нэрийн данснаас дараах байдлаар тооцохоор тусгасан:

- хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бол сүүлийн гурван жилийн дундаж сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 60 хувиар;
- хөдөлмөрийн чадвараа хагас алдсан бол сүүлийн гурван жилийн дундаж сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос хөдөлмөрийн чадвараа алдсан хувьд ногдох хэмжээгээр бодож тогтооно.

Харин тэжээгчээ алдсаны тэтгэврийг нэрийн данснаас дараах байдлаар тооцохоор заасан:

- хөдөлмөрийн чадваргүй нэг хүнтэй бол сүүлийн гурван жилийн дундаж сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 40 хувиар;
- хөдөлмөрийн чадваргүй хоёр ба түүнээс дээш хүнтэй бол гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй хүн тус бүрт дээрх 40 хувийг 10 хувиар нэмэгдүүлнэ. Гэхдээ энэ тэтгэврийн дүн нь сүүлийн гурван жилийн дундаж сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 60 хувиас хэтрэхгүй байна гэжээ.

Жишээ авч 1995 оны хууль болон нэрийн дансны хуулийн дагуу харьцуулан бодолт хийснийг дараах хүснэгтэд харуулав:

Хүснэгт 6. Даатгуулагчдад тогтоох тэтгэврийн хэмжээний тооцоолол

№	Үзүүлэлт	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль /1995 оны/	Нэрийн дансны хуулиар /1999 оны/
1	Үндсэн мэдээлэл: Даатгуулагч 1960 онд төрсөн, 30 жил шимтгэл төлж ажилласан, 2010 онд хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан		
	Цалингийн дундаж	1 000 000	1 000 000
	Тэтгэвэр бодох томъёо	$T = ДЦ \times ((45_{\text{хувь}} + (1.5_{\text{хувь}}) \times (X_{\text{нийт жил}} - 20_{\text{жил}})) \times \frac{IP_{\text{хувь}}}{IP_{\text{хувь}}})$	$T = ДЦ \times IP_{60 \text{ хувь}}$
	Тогтоох тэтгэврийн хэмжээ	600 000 төгрөг	600 000
2	Үндсэн мэдээлэл: Даатгуулагч 1960 онд төрсөн, 3 жил шимтгэл төлж ажилласан, 2010 онд хөдөлмөрийн чадвараа 50 хувь буюу хагас алдсан		
	Цалингийн дундаж	1 000 000	1 000 000
	Тэтгэвэр бодох томъёо	$T = ДЦ \times \frac{T_{\text{хувь}}}{240_{\text{сар}}} \times X_{\text{нийт сар}} \times \frac{IP_{\text{хувь}}}{IP_{\text{хувь}}}$	$T = ДЦ \times IP_{\text{хувь}}$
	Тогтоох тэтгэврийн хэмжээ	33 750 /216 000/	500 000

Дээрх тооцооллоос үзэхэд нэрийн дансны хуулиар тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгох нь 1995 оны хуулиас ихэнхи тохиолдолд өндөр байх магадлалтай байна. Гэвч өнөөг хүртэл хугацаанд тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэврийг нэрийн дансны 1999 оны хуулиар тогтоолгосон 1960 ба түүнээс хойш төрсөн даатгуулагч байхгүй байгаа ба бүгд 1995 оны хуулиар тогтоолгожээ.

Учир нь нэрийн дансны хуульд энэ 2 төрлийн тэтгэврийг ямар эх үүсвэрээс ямар хугацаанд олгох, хэрвээ даатгуулагчийн нэрийн дансны үлдэгдэл дууссан тохиолдолд хэрхэх тухай зохицуулалт огт тусгаагүй болно.

## Дүгнэлт

1999 оны хуулиар хийсвэр тооцоолсон нэрийн дансны үлдэгдэл буюу шимтгэлд суурилсан тэтгэвэр тогтоох тогтолцоог нэвтрүүлэхдээ шимтгэл төлөөгүй үед ажиллаж байсан 1960-1980 онд төрсөн хүмүүсийг хамруулахаар тусгасан нь алдаа байсан;

- 1960 ба түүнээс хойш 1980 он хүртэл төрсөн иргэд 1995 он хүртэл буюу шимтгэл төлж эхэлсэн шинэ хуулийн зохицуулалт гарах хүртэл 15 хүртэл жилийн ажилласан хугацаатай байсан бөгөөд нийгмийн шилжилт, эдийн засгийн нөхцөл байдал, ажилгүйдэл, хуулийн мэдээлэлгүй зэргээс болж шимтгэл төлсөн жил нь хангалттай нэмэгдээгүй;
- Хийсвэр нэрийн дансны эхний үлдэгдэл тооцох тооцоог алдаатай хийсэн;
- Хийсвэр нэрийн дансанд жил бүр тооцох хүү нь инфляци, хадгаламжийн хүүгээс ихэнхидээ өндөр тогтоогдож ирсэн боловч шимтгэл төлсөн хугацаа богино, шимтгэлийн хувь хэмжээ болон шимтгэл төлсөн цалин бага байснаас нэрийн дансанд төлсөн шимтгэл 1960-1980 онд төрсөн хүмүүсийн хувьд хангалттай өндөр байж чадаагүй;
- Хийсвэр нэрийн дансанд жил бүр тооцох хүүг цалингийн өөрчлөлттэй хамаатай байхаар хуульчилсан цалинг улс төрийн шалтгаанаар огцом нэмэгдүүлсэн бол үндэслэлгүй өндөр хүү тогтоож, улмаар хийсвэр нэрийн дансны үлдэгдлийн 88.8 (1960 оных) хувийг зөвхөн бодсон хүү эзлэх сөрөг үр дагавартай болсон;
- Тэтгэврийн доод хэмжээг 1995 оны хуулиар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50;75 гэж заасан боловч 2017 оны байдлаар 90;105 хувьтай тэнцэж байгаа нь 1999 оны хуулиар өндөр байгаа тул тэтгэврийн доод хэмжээнд шууд зөрүү үүсч байна;

## Санал

- 1999 оны хуулийг хэрэгжүүлэх огноог 1980 ба түүнээс хойш байхаар хуульд өөрчлөлт оруулах;
- Хийсвэр нэрийн дансанд жил бүр тооцох хийсвэр хүүний хэмжээг Швейцар индекс эсвэл хугацаатай хадгаламжийн хүүний өсөлт-80%, цалингийн өсөлт-20 % байхаар хуульд өөрчлөлт оруулах;

- Тэтгэврийн доод хэмжээг 1995 оны хуулиар тогтоосон доод хэмжээтэй уялдуулж, 1980-1990 он хүртэл хугацааны өндөр зөрүүг аажмаар багасгах түр хугацааны нэмэлт санхүүжилтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Цаашид 1999 оны хуульд тэтгэврийн доод хэмжээг байхгүй болгож, тэтгэврийн олон давхаргат тогтолцоотой уялдуулах (суурь болон нэмэлт тэтгэвэр);
- Нэрийн дансны хуримтлалаас 5-8 хувийг дэд дансанд хуримтлуулж энэ дүнгээс тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэврийг тодорхой хугацаанд олгох зохицуулалтыг хийх, хэрвээ даатгуулагч энэ дүнг ашиглаагүй бол үндсэн дүнд нэмж тооцон өндөр насны тэтгэвэрт зарцуулах зохицуулалт хийх;
- Хийсвэр нэрийн дансны үлдэгдэлтэй боловч тэтгэвэрт гарахаас өмнө болон гарсны дараа нас барсан бол нэг удаагийн буцаалтыг ар гэрт нь олгох зохицуулалт хийх;
- Тахир дутуугийн тэтгэврийг бодох аргачлал хэт өгөөмөр байгааг өөрчлөх, багасгах;
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 14% - 19 % болгож нэмэгдүүлэх зэрэг тус тус болно.

### **Ашигласан материал**

1. “Нийгмийн даатгалын холбогдолтой эрх зүйн актын эмхтгэл”УНДЕГ УБ, 1995, 1997, 2000, 2005, 2007, 2008, 2012
2. “Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаатай холбогдолтой тогтоол, тушаал, заавар, аргачлал, журмын эмхтгэл” Н Д Е Г , УБ, 2012
3. “Нийгмийн даатгалын тухай эрх зүйн актууд” НДЕГ УБ, “Бит пресс” ХХК, 2013
4. “Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл” НДЕГ, УБ, “Мөнхийн үсэг” ХХК, 2012
5. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2014 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 30 дугаар тогтоол
6. “Нийгмийн даатгал” сурах бичиг, Б.Батжаргал Удам соёл ХХК 2016
7. Монгол Улсын тэтгэврийн даатгалын сангийн бүрдэлт хуваарилалтын тулгамдсан асуудал Н.Тунгалаг (профессор), Л.Оюунцэцэг (доктор) нар 2013 он
8. “Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн ойлголтууд цуврал-Тэтгэврийн тогтолцооны тухай үндсэн үзэл баримтлалууд” Дэлхийн банк УБ,



2012

9. “Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн ойлголтууд цуврал-Баталгаа” Дэлхийн банк УБ, 2012
10. “Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн ойлголтууд цуврал-Тэтгэврийн даатгалд хамрагдалт” Дэлхийн банк УБ, 2012
11. “Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн ойлголтууд цуврал-Тэтгэврийн хийсвэр нэрийн дансны тогтолцоо” Дэлхийн банк УБ, 2012
12. “Тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийн талаарх олон улсын туршлага, сургамж” Марк Дорфман, Ахлах эдийн засагч, Дэлхийн банк, 2015.
13. “Тэтгэврийн шинэчлэлийн үндсэн ойлголтууд цуврал-Тэтгэвэр тогтоолт” Дэлхийн банк УБ, 2012
14. “Шимтгэлтэй дүйцэх татаастай тэтгэврийн хөтөлбөрүүд” Дэлхийн банк УБ, “Хөх монгол принтинг” ХХК, 2015
15. “International Patterns of Pension Provision II”, Montserrat Pallares-Miralles, Carolina RomeroWB 2012
16. “Pension reform” Robert Holzmann, Edward Palmer, World bank 2006
17. “Social security pensions” Colin Gillion, John Turner, Clive Bailey, Denis Latuipe ILO, Geneva 2011
18. Монголбанкны Mongolbank.mn цахим хуудас
19. ҮСХ-ны 1212.mn цахим хуудас
20. www.ndaatgal.mn
21. www.legalinfo.mn
22. www.1212.mn